БАТЛАВ.
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

Д.ҮҮРИЙНТУЯА

2026 оны 11 дүгээр сарын 03

АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг. Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

1.1. Хууль зүйн үндэслэл:

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлд хүнийг хүйсээр ялгаварлан гадуурхахыг хориглож, хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх үндсэн зарчмыг баталгаажуулсан. Мөн Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 9 дэх хэсэгт төрийг удирдах хэрэгт оролцох, сонгох, сонгогдох эрхийг иргэнд баталгаатай эдлүүлэхээр заасан.

Эдгээр үндсэн эрхийг бодитой хэрэгжүүлэх, улс төрийн шийдвэр гаргалтад эмэгтэй, эрэгтэй хүний тэгш оролцоог хангах зорилгоор Монгол Улс жендэрийн эрх тэгш байдлыг хангах, улс төрийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр үе шаттайгаар эрх зүйн зохицуулалтыг бий болгож ирсэн.

Гэвч өнөөгийн эрх зүйн зохицуулалтад улс төрийн оролцооны өөр өөр түвшинд жендэрийн төлөөллийн шаардлага харилцан адилгүй байна. Тухайлбал, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 8.3-т улс төрийн намын өөрийн төлөөллийн төв болон орон нутгийн байгууллагын бүрэлдэхүүнд аль нэг хүйсийн төлөөлөл 40 хувиас доошгүй байх, Улс төрийн намын тухай хуулийн 17.7-д намын төлөөллийн төв, гүйцэтгэх төв болон хяналтын байгууллагын бүрэлдэхүүнд аль нэг хүйсийн төлөөлөл 40 хувиас доошгүй байхыг тус тус хуульчилсан байна.

Мөн Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 30.2-т нам, эвслээс нэр дэвшүүлэхэд 2024 оны ээлжит сонгуулиар нийт нэр дэвшигчийн 30-аас доошгүй хувь, 2028 оны ээлжит сонгуулиар 40-өөс доошгүй хувь нь аль нэг хүйсийнх байхаар шаталсан зохицуулалт тогтоосон.

Харин Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 29.2-т нам, эвслээс нэр дэвшиж байгаа нэр дэвшигчийн 20-оос доошгүй хувь нь аль нэг хүйсийн нэр дэвшигч байхаар одоогийн зохицуулалт хэвээр байна.

Иймхүү улс төрийн намын дотоод байгуулалт, Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвшүүлэх харилцаанд 40 хувийн шаардлага тавьж байгаа боловч нутгийн өөрөө удирдах байгууллагыг бүрдүүлэх орон нутгийн сонгуульд 20 хувийн босго хэвээр

байгаа нь улс төрийн шийдвэр гаргах түвшин дэх жендэрийн төлөөллийн бодлогын нэгдмэл байдлыг алдагдуулсан, хууль хоорондын зөрчил үүсгэсэн байна.

Хэрэв одоогийн 20 хувийн зохицуулалтыг хэвээр үлдээвэл улс төрийн намын дотоод байгуулалт, Улсын Их Хурлын сонгууль болон орон нутгийн сонгуулийн хооронд жендэрийн төлөөллийн эрх зүйн босго ялгаатай хэвээр үлдэнэ.

Ингэснээр улс төрийн шийдвэр гаргах орон нутгийн түвшинд эмэгтэйчүүдийн төлөөлөл хангалтгүй байх нөхцөл үргэлжилж, Монгол Улсын жендэрийн эрх тэгш байдлын бодлого, олон улсын зөвлөмжийн хэрэгжилт удаашрах эрсдэлтэй. Асуудлыг зөвхөн бодлогын арга хэмжээ, улс төрийн намын дотоод зохицуулалтаар бус, сонгуулийн эрх зүйн үндсэн зохицуулалтын нийцэл, уялдааг хангах замаар шийдвэрлэх шаардлагатай гэж үзэж байна.

1.2. Практик хэрэгцээ, шаардлага:

Орон нутгийн өөрөө удирдах байгууллага нь иргэдийн нийтлэг ашиг сонирхлыг төлөөлөх, тухайн нутаг дэвсгэрийн хөгжлийн бодлого, төсөв, хөрөнгө оруулалт, нийгэм, эдийн засгийн асуудлаар шийдвэр гаргах үндсэн институц юм. Иймд иргэдийн төлөөллийн байгууллагын бүрэлдэхүүнд эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн оролцоо, төлөөллийг бодитой, тэнцвэртэй хангах нь төлөөллийн ардчиллыг бэхжүүлэх, шийдвэр гаргах үйл явцад нийгмийн бүлгүүдийн ашиг сонирхлыг бүрэн тусгах чухал нөхцөл юм.

Өнөөгийн эрх зүйн зохицуулалтаар улс төрийн нам, эвслээс нэр дэвшүүлэхэд хүйсийн төлөөллийн 20 хувийн доод босго тогтоосон боловч энэ нь орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд сонгогдсон төлөөлөгчдийн хүйсийн тэнцвэртэй байдлыг хангахад хангалтгүй байна.

Тухайлбал, 2024 оны орон нутгийн сонгуулийн үр дүнгээр аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нийт төлөөлөгчдийн 17.9 хувь, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн 28.5–28.8 орчим хувь нь эмэгтэй байна. Ялангуяа аймаг, нийслэлийн түвшинд эмэгтэй төлөөлөгчдийн эзлэх хувь 17.9 байгаа нь орон нутгийн бодлого, төсөв, хөгжлийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн төлөөлөл хангалтгүй байгааг харуулж байна.

Энэхүү нөхцөл байдал нь зөвхөн нэр дэвшигчдийн тооноос хамаарахгүй бөгөөд улс төрийн намын нэр дэвшүүлэх үйл явц, нэр дэвшигчдийн сонгогдох бодит боломж, сонгуулийн санхүүжилт, улс төрийн орчин, жендэрийн хэвшмэл ойлголт зэрэг олон хүчин зүйлтэй холбоотой. Гэсэн хэдий ч нэр дэвшигчийн хүйсийн төлөөллийн доод квот нь улс төрийн оролцоонд тулгарч буй бүтцийн саадыг бууруулах, эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн тэгш боломжийг нэмэгдүүлэх үндсэн эрх зүйн арга хэрэгслийн нэг юм.

Иймд одоо мөрдөж буй 20 хувийн доод босгыг 40 хувь болгон нэмэгдүүлэх замаар улс төрийн нам, эвслээс нэр дэвшүүлэх шатанд хүйсийн төлөөллийг бодитой хангах эрх зүйн нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байна. Гэхдээ нийт нэр дэвшигчийн 40 хувийн квот тогтоох нь хүйсийн төлөөлөл нэр дэвшигчдийн нэрийн жагсаалтын дараалал болон сонгуулийн тойрог тус бүрд бодитоор хангагдахыг

дангаараа баталгаажуулахгүй. Учир нь нэр дэвшигчдийн жагсаалтад эзлэх байрлал, олон мандаттай тойрогт нэр дэвшигчдийн бүрэлдэхүүн нь тэдний сонгогдох боломжид шууд нөлөөлдөг.

Тиймээс хүйсийн төлөөллийн квотын хэрэгжилтийг зөвхөн нийт нэр дэвшигчийн түвшинд бус, нэр дэвшигчдийн нэрийн жагсаалтын дараалал болон сонгуулийн тойрог тус бүрийн түвшинд хангах шаардлагатай. Энэ хүрээнд нэр дэвшигчдийн нэрийн жагсаалтад эрэгтэй, эмэгтэй нэр дэвшигчийг сөөлжлүүлэн байрлуулах, гурав ба түүнээс дээш мандаттай сонгуулийн тойрог тус бүрд нэр дэвшүүлсэн нэр дэвшигчдийн хүйсийн төлөөлөлд 40 хувийн доод шаардлага тогтоох нь нийт квотын хэрэгжилтийг бодитой болгох, нэр дэвшигчдийн сонгогдох боломжийг тэнцвэржүүлэх харилцан уялдаатай зохицуулалт болно.

Иймд хуулийн төсөл нь нэр дэвшүүлэх шатанд хүйсийн төлөөллийн доод босгыг нэмэгдүүлэхээс гадна нэр дэвшигчдийн жагсаалтын дараалал, сонгуулийн тойрог тус бүрд хүйсийн төлөөллийг хангах замаар орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэр гаргах түвшинд эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн тэгш оролцоог нэмэгдүүлэх практик хэрэгцээ, шаардлагад үндэслэж байна.

1.3. Олон улсын зөвлөмж, Монгол Улсын хүлээсэн үүрэг:

Монгол Улс Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенцод нэгдэн орсон бөгөөд уг конвенцын хүрээнд эмэгтэйчүүдийн улс төрийн болон нийтийн амьдралд тэгш оролцоог хангах үүрэг хүлээдэг.

НҮБ-ын CEDAW-ийн хороо 2022 онд Монгол Улсын тайланг хэлэлцээд эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо, ялангуяа шийдвэр гаргах түвшинд төлөөлөл хангалтгүй байгаад анхаарал хандуулж, парламент болон орон нутгийн сонгуульд улс төрийн намын нэрийн жагсаалтаар нэр дэвшигчдийн дунд эмэгтэйчүүдийн доод квотыг 30 хувьд хүргэх, квотын хэрэгжилтэд хяналт тавих, зөрчилд үр нөлөөтэй арга хэмжээ авахыг зөвлөсөн.

Түүнчлэн CEDAW-ийн хороо эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо болон шийдвэр гаргах түвшинд дутуу төлөөлөгдөж байгаа байдлыг арилгахын тулд хугацаатай зорилт, шалгуур үзүүлэлт бүхий түр тусгай арга хэмжээг хэрэгжүүлэхийг зөвлөсөн.

Монгол Улс 2023 онд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 8.3 дахь хэсгийн квотыг 25 хувиас 40 хувь болгон нэмэгдүүлсэн нь үндэсний хууль тогтоомжийн түвшинд жендэрийн төлөөллийг үе шаттай нэмэгдүүлэх бодлогын чиглэл тогтсоныг харуулж байна.

Иймд орон нутгийн сонгуулийн нэр дэвшигчийн квотыг 20 хувиас 40 хувь болгон нэмэгдүүлэх нь Монгол Улсын үндэсний хууль тогтоомжийн хөгжлийн чиг хандлага болон олон улсын зөвлөмжтэй нийцнэ.

Хоёр. Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

2.1. Хуулийн төслийн зорилго:

Хуулийн төслийн зорилго нь орон нутгийн Хурлын сонгуульд нам, эвслээс нэр дэвшүүлэх үед аль нэг хүйсийн нэр дэвшигчийн эзлэх доод хувийг 20 хувиас 40 хувь болгон нэмэгдүүлж, улс төрийн шийдвэр гаргах орон нутгийн түвшинд эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн тэгш оролцоо, төлөөллийг нэмэгдүүлэх, түүнчлэн хуулийн 29.2-т заасан нэр дэвшүүлэх ажиллагааны журмын хэрэгжилтийг хангах эрх зүйн үндэслэлийг бүрдүүлэхэд оршино.

Уг өөрчлөлт нь сонгуульд нэр дэвших эрхийг хүйсээр хязгаарлах бус, улс төрийн шийдвэр гаргалтад бодит тэгш оролцоог хангахад чиглэсэн тусгай арга хэмжээ байна. Мөн нэр дэвшүүлэх ажиллагааны журамд тавигдсан шаардлагыг мөрдүүлэх, зөрчигдсөн тохиолдолд хуульд заасан үр дагаврыг хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгоно.

2.2. Хуулийн төслийн ерөнхий бүтэц:

Хуулийн төсөл нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4, 29.5, 32 дугаар зүйлийн 32.1.10, 32.1.11 дэх хэсэгт нэмэлт оруулах, 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэгт өөрчлөлт оруулах, түүнчлэн хуулийг дагаж мөрдөх хугацааг тусгайлан тогтоосон нийт 3 зүйлтэй байна.

2.3. Зохицуулах харилцаа:

Хуулийн төслийн зохицуулалт нь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нам, эвслээс нэр дэвшүүлэх үйл ажиллагаанд хамаарна.

Бие даан нэр дэвшигчид хамаарахгүй. Учир нь одоо мөрдөж буй хуулиар бие даан нэр дэвших эрхийг тусад нь зохицуулсан бөгөөд жендэрийн квот нь нам, эвслийн нэр дэвшүүлэлтийн үйл ажиллагаанд чиглэж байна.

2.4. Хуулийн төслийн хамрах хүрээ:

Хуулийн төсөлд улс төрийн нам, эвсэл, тэдгээрээс нэр дэвшигчид болон нэр дэвшигчийг бүртгэх сонгуулийн байгууллагын үйл ажиллагаа хамаарна.

Энэхүү төсөл нь сонгогчийн сонгох эрх, нэр дэвшигчийн бусад шаардлага, сонгуулийн тогтолцоо, мандатын хуваарилалт болон бие даан нэр дэвших эрхийг өөрчлөхгүй.

Харин нам, эвслээс нэр дэвшүүлэх ажиллагаанд хуулийн 29.2, 29.4, 29.5-д заасан шаардлагыг зөрчсөн тохиолдолд нийт нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзах эрх зүйн үр дагаврыг сонгуулийн байгууллагын бүртгэлийн ажиллагаанд хамааруулан зохицуулна.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар

Хуулийн төсөл батлагдсанаар эмэгтэй, эрэгтэй иргэдийн орон нутгийн улс төрийн оролцоо, төлөөллийн тэнцвэрийг хангах эрх зүйн боломж нэмэгдэж, нутгийн

өөрөө удирдах байгууллагын шийдвэр гаргах түвшинд хүн амын төлөөлөл илүү хүртээмжтэй болох эерэг нийгмийн үр дагавартай.

Нийт нэр дэвшигчийн 40 хувийн доод квотыг нэр дэвшигчийн жагсаалтад эрэгтэй, эмэгтэй нэр дэвшигчийг сөөлжлүүлэн байрлуулах болон гурав ба түүнээс дээш мандаттай тойрог тус бүрд 40 хувийн төлөөлөл хангах зохицуулалттай хамтатгаснаар хүйсийн төлөөлөл зөвхөн нийт нэр дэвшигчийн тоогоор хязгаарлагдахгүй, нэр дэвшигчийн жагсаалтын дараалал болон тойрог тус бүрд бодитоор хангагдах нөхцөл бүрдэнэ.

Орон нутгийн хөгжлийн бодлого, төсөв, нийгмийн үйлчилгээ, гэр бүл, хүүхэд, хөдөлмөр эрхлэлт зэрэг иргэдийн өдөр тутмын амьдралтай шууд холбоотой асуудлаар шийдвэр гаргах үйл явцад эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн оролцоог нэмэгдүүлэх нь бодлогын олон талт байдлыг хангахад эерэг нөлөө үзүүлнэ.

Хуулийн төсөл хэрэгжсэнээр төрийн болон улс төрийн байгууллагын жендэрийн төлөөллийн талаарх хууль тогтоомж хоорондын уялдаа сайжирна. Ялангуяа Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль болон Улс төрийн намын тухай хуульд тогтоосон 40 хувийн зохицуулалттай орон нутгийн сонгуулийн нэр дэвшигчийн квотыг уялдуулах эрх зүйн үндэс бүрдэнэ.

Мөн нийт нэр дэвшигчийн квот, нэр дэвшигчийн жагсаалтын сөөлжлүүлсэн дараалал, олон мандаттай тойрог тус бүрийн квотыг харилцан уялдаатай хэрэгжүүлэх замаар жендэрийн төлөөллийн шаардлагыг нэр дэвшүүлэх ажиллагааны үе шат бүрд хангах, хэрэгжилтийг хянах эрх зүйн үндэс бүрдэнэ.

Хуулийн төсөл хэрэгжсэнээр улсын төсөвт шууд нэмэлт зардал бий болгохгүй. Харин улс төрийн нам, эвсэл нэр дэвшүүлэх ажиллагаагаа шинэ шаардлагад нийцүүлэн зохион байгуулах, нэр дэвшигчдийн сонгон шалгаруулалт, сургалт, чадавхжуулалтад тодорхой зохион байгуулалтын зардал гарах боломжтой.

Хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Сонгуулийн ерөнхий хорооноос нэр дэвшигч бүртгэх, мэдээлэх үйл ажиллагаанд хүйсээр ангилсан мэдээллийг тогтмол гаргаж, сонгуулийн дараа нэр дэвшигч болон сонгогдсон төлөөлөгчдийн хүйсийн харьцаанд дүн шинжилгээ хийх нь зүйтэй.

Мөн улс төрийн намууд нэр дэвшигчдэд зориулсан сургалт, чадавхжуулалт, сонгуулийн санхүүжилтийн бодлогод жендэрийн тэгш байдлыг тусгаж, эмэгтэй нэр дэвшигчдийн улс төрийн оролцоог бодитоор дэмжих шаардлагатай.

Квотыг 40 хувь болгон нэмэгдүүлэх нь нэр дэвшигчийн түвшинд тэгш боломжийг нэмэгдүүлэх үндсэн арга хэмжээ бөгөөд цаашид сонгогдсон төлөөлөгчдийн жендэрийн харьцаа, нэр дэвшигчдийн тойрогт байршуулалт, сонгуулийн тогтолцооны үр нөлөөг тусгайлан үнэлж, шаардлагатай бол нэмэлт бодлогын арга хэмжээ авах нь зүйтэй.

Дөрөв. Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээ болон бусад хуультай уялдсан байдал, бусад хуульд оруулах өөрчлөлтийн талаар:

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуулийн хүний эрх, эрх чөлөө, тэгш байдлыг хангах, төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхийг баталгаажуулсан зохицуулалттай нийцнэ. Жендэрийн квот нь аль нэг хүйсийн төлөөлөл хангалтгүй байгаа нөхцөлд тэгш боломжийг бодитоор хангахад чиглэсэн тусгай арга хэмжээний шинжтэй бөгөөд хүний сонгох, сонгогдох эрхийн үндсэн агуулгыг үгүйсгэхгүй.

Монгол Улсын нэгдэн орсон Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенцын 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан тусгай арга хэмжээний үзэл баримтлалтай нийцнэ. Тус конвенцын Хороо 2022 онд Монгол Улсад өгсөн дүгнэлтдээ парламентын болон орон нутгийн сонгуульд эмэгтэй нэр дэвшигчийн доод квот тогтоох, квотын хэрэгжилтийг хангах үр дүнтэй механизм, зөрчилд хүлээлгэх арга хэмжээ бий болгохыг зөвлөсөн.

Хуулийн төсөл нь Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 8.3 дахь хэсэгт заасан улс төрийн намын төв болон орон нутгийн байгууллагын бүрэлдэхүүнд аль нэг хүйсийн төлөөллийг 40 хувиас доошгүй байлгах шаардлага, Улс төрийн намын тухай хуулийн 17.7 дахь хэсэгт заасан намын удирдах болон хяналтын байгууллагын 40 хувийн төлөөллийн шаардлагатай нийцнэ.

Мөн Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд 2028 оны ээлжит сонгуулиас нэр дэвшигчийн аль нэг хүйсийн төлөөллийг 40 хувиас доошгүй байхаар тогтоосон зохицуулалттай уялдана.

---o0o---